

Ахмад настнуудыг аэробек, хийн дасгалаар хичээллүүлэх замаар нас, биеийн онцлогт тохирсон идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхэд дэмжлэг үзүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх ахмад настны тоог нэмэгдүүлэх зорилгоор 2016 оны 08 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд сумын Эрүүл мэндийн төв, Говьсүмбэр аймгийн Төмөр замын Ахмадын хорооны сургагч багш нартай хамтран сургалт зохион байгууллаа.

Сургалтанд нийт 18 ахмад настан хамрагдсан бөгөөд сургалтын үеэр эрүүл мэндийн анхан шатны үзлэг хийгдэж, ахмадуудын биеийн байдалд хяналт тавьж ажилласан. Ахмад настнуудын дундах хөдөлгөөн дутагдал, артерийн даралт ихсэлт зэрэг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дэмжин цаашид ахмадын хийн дасгал Аэробекийн клуб хичээллүүлэх зорилго тавин ажиллаж байна.

